

Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн асуудал

The Issue of University Curriculum that Trains Accountants

Л. Дондог¹

Хураангуй

Монгол Улсад нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг 41 их сургууль байгаагаас хамгийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 10 сургуулийг сонгон авч, сургалтын хөтөлбөр боловсруулсан байдалд судалгаа хийхэд нийтлэг хэд хэдэн дутагдлууд байна. Эдгээр дутагдлуудыг арилгахын тулд Боловсролын олон улсын стандартыг нэн даруй нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд их сургууль, боловсролын асуудлыг удирдах төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа чухал гэж үзсэн.

Түлхүүр үгс: сургалтын хөтөлбөр, боловсролын олон улсын стандарт, нягтлан бодогч мэргэжилтний техник чадамж, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлага

Abstract

There are 41 universities in Mongolia that train accountants. The author selected the 10 most active schools and conducted a study on curriculum development. The several shortcomings were noted in the training program for accountants at the 10 universities mentioned above. The author believes that the immediate introduction of international standards of education is necessary to address the shortcomings. To this end, this article discusses the issues of cooperation between governmental and non-governmental organizations that manage universities and education.

Keywords: curriculum, international educational standards, technical competence of an accountant, professional skills, professional values, ethics and attitudes

¹ Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн, Доктор (Ph.D)
E-mail: l_dondog@yahoo.com

Дэлхийн эдийн засгийн форумас 2019 онд гаргасан “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2019”-д Монгол Улсын өрсөлдөх чадварыг дэлхийн 141 улсуудтай харьцуулахад 102-т эрэмбэлэгдсэн бөгөөд түүний дотор нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хэрэглээний түвшингээр 116 дугаарт, одоогийн ажиллах хүчний ур чадварын түвшин 119 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Нягтлан бодогчдын үйл ажиллагаа, ур чадвар улсынхаа хөгжлийг хойш чангааж байгаа шалтгааныг олж тогтоох, засч залруулах асуудал чухал болж байна.

2017 онд НББ-ийн хүрээлэнгийн судалгаагаар тус судалгаанд хамрагдсан 324 аж ахуйн нэгжийн 56.5 хувь СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэдэг бөгөөд бусад нь хагас дутуу мөрддөг гэсэн дүн гарчээ. СТОУС-ын мэдлэгийн талаар нягтлан бодогчид өөрийгөө үнэлсэн байдлаас үзэхэд, судалгаанд оролцогчдын 34 хувь нь сайн ба түүнээс дээш, харин 66 хувь нь дунд ба түүнээс доош мэдлэгтэй гэжээ. Мөн нягтлан бодогчдын 61.7 нь хувь СТОУС-ын сургалтад суугаагүй, эсвэл нэг удаа оролцсон гэж хариулжээ. Мөн судалгаанд оролцогчид СТОУС-ын мэдлэгийг их, дээд сургуульд суралцаж байхдаа 46.1 хувь нь сайн эзэмшсэн гэсэн бол 63.9 хувь нь сайн эзэмшиж чадаагүй гэжээ. 2020 онд манай ажлын хэсгийн хийсэн судалгаагаар 2017 оны дүр төрх мөн л давтагдаж байв. Үүнээс үзэхэд ажиллаж байгаа нягтлан бодогчдын талаас бага хэсэг нь СТОУС-ын мэдлэгийг оюутан байхдаа тааруу эзэмшсэн, ажил дээр гараад түүнийг бүрэн эзэмших гэж оролддоггүй, үүнээс шалтгаалаад СТОУС-ын нэвтрэлт мөн л хагас дутуу байгаа байдал харагдаж байна. СТОУС-ын нэвтрэлтийг дэмжихийн тулд нягтлан

бодогч мэргэжилтэн бэлтгэх шатанд болон ажиллаж байгаа нягтлан бодогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудалд анхаарах нь чухал болохыг энэ баримт өгүүлж байна.

Дэлхийн банк, Сангийн Яамны захиалгаар 2020 оны сүүлчээр Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд Монгол Улсын нягтлан бодогчдын чадавхийг бэхжүүлэх асуудлаар хийсэн судалгааны зөвлөмж, тайланд дээр дурдсан асуудлыг тусгасан болно (Сангийн Яам, 2021).

Даяарчлал, техник, технологийн дэвшил болон орчны өөрчлөлтүүд нь бизнесийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн зах зээлийн бүтцэд ихээхэн хувиралтыг авчрах болсон нь аливаа улс орны боловсролын системийг бүхэлд нь шинэчлэх шалтгаан нь болж байна. Одоогийн боловсролын систем нь үеэ өнгөрөөсөн масс үйлдвэрлэлийн систем учраас өнөөгийн нийгэм болон технологийн өөрчлөлтийн үед тохирсон боловсролын цогц системийн шинэчлэлийн эрэл хайгуулыг дэлхийн улс орон бүр хийж байна. Шинэчлэлийн тэргүүнд Австрали, Финлянд, Канад, Герман, Япон улсууд яваа бөгөөд тэд технологийн дэвшлийг дагуулах чадвар бүхий, мөн ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, ингэснээр насан туршийн амьдралын чанарыг баталгаажуулах боловсролыг олгох явдал гэж өөрчлөлтийн агуулгыг тодорхойлж байна.

Сүүлийн жилүүдэд дээд боловсролын салбарт багш төвтэй сургалтаас суралцагч төвтэй сургалтад, орцыг бус гарцыг чухалчлан үзэж, суралцахуйн үр дүнг оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаар тодорхойлж, зөвхөн мэдлэг

бус онол, практикийг хослуулан хэрэглэх чадвартай, насан туршийн суралцагчийг бэлтгэх асуудал тулгарч байна.

Суралцагчид мэргэжлийн ур чадварыг эзэмшихээс гадна хувь хүний, хувь хүн хоорондын харилцааны болон шинэ бүтээгдэхүүн, систем, үйл ажиллагааг бий болгох чадваруудыг олгоход чиглэсэн харилцан уялдаа бүхий хичээлүүдээс бүрдсэн уян хатан, интеграл сургалтын төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээ бий болоод байна.

Дээд боловсролын шинэчлэлийн чиг хандлага нь сургалтын орц, явцыг бус харин гарц, үр дүн (чадамж)-г чухалчилсан тогтолцоонд шилжихийн тулд сургалтын хөтөлбөрт сургалтын эцэст оюутны сурсан байх ёстой мэдлэг, чадварыг буюу гарах үр дүнг урьдчилан нарийн тодорхойлж, тэрхүү үр дүнд хүрсэн эсэхийг хянахыг чухалчилдаг. Энэ нь үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлал юм.

Өнөөгийн нөхцөл байдал

Манай улсад дээд боловсролын талаар баримтлах бодлого, Сургалтын хөтөлбөр боловсруулах журам, Үр дүнд суурилсан үндэсний хөтөлбөр гэх мэт бодлого, шийдвэр хангалттай батлан гарч байгаа боловч түүний хэрэгжилт тааруу байна. Бид нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг 41 сургуулиас хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 10 сургуулийг сонгон авч, сургалтын хөтөлбөр боловсруулсан байдалд судалгаа хийв (Сангийн Яам, 2021).

Судалгаанаас үзэхэд нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр нь олон улсын магадлан итгэмжлэлд орсон сургуулиудын хувьд орчин үед тавигдах шаардлагыг хангасан, мөн дотоодын магадлан итгэмжлэлд орсон

сургуулиуд шаардлагад нэлээд дөхсөн байгаа бол магадлан итгэмжлэлд ороогүй сургуулиудын хөтөлбөр шаардлага хангахгүй байлаа.

Дээр дурдсан 10 их сургуулийн нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт судалгаа хийх явцад дараах дутагдал байв. Үүнд:

1. Ихэнх сургууль 2014 онд БСШУ-ны сайдын А/174 тоот тушаалаар “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” батлагдсаны дараа тэр жилдээ багтаж бүх сургуулиуд хэтрүүлж хэлбэл “коммунист субботник” байдлаар сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулсан байдаг. Сургалтын хөтөлбөрийг сургуулиуд жил бүр нийгмийн хэрэгцээ, ажлын байрны шаардлагад нийцүүлэн шинэчилж байх ёстой боловч ихэнх сургууль ингэж ажиллаагүй, бараг салхи ч оруулаагүй хав дарчихсан байв. Гэхдээ энд сургалтын хөтөлбөрийг өөрчилж, шинэчилсэн, гадаад, дотоодод хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж амжилттай үр дүнд хүрч байгаа МУИС, СЭЗИС зэрэг сургуулиуд байна.
2. Жилээс жилд нягтлан бодогч мэргэжилтний ажиллаж байгаа ажлын байранд шинэ өөрчлөлт болж, шинэ мэдлэг, арга барил, ур чадвар шаардаж байхад нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэж байгаа ихэнх сургуулиуд ажлын байрны судалгаагүй масс үйлдвэрлэл явуулсаар иржээ. Энэ судалгааны хүрээнд багш нараас авсан судалгаагаар “Танай сургуулийн төгсөгчид ямар чадварыг хамгийн сайн эзэмшсэн бэ?” гэсэн асуултад “Шинжлэх, судлах, асуудал шийдвэрлэх чадвар”-ыг сайн ба маш

сайн эзэмшдэг гэж 81 хувь нь, “Туршилт судалгаа хийх, мэдлэг бүтээх чадвар”-ыг сайн, маш сайн эзэмшдэг гэж 77 хувь, “Мэргэжлийн ёс зүй шударга байх, үүрэг хүлээх чадвар”-ыг сайн, маш сайн эзэмшдэг гэж 85 хувь нь хариулжээ. Гэтэл төгсөгчдөөс авсан судалгаагаар, “Манай сургуулийн НББ хөтөлбөрөөр орчин үед нийгмийн хүлээж буй хэрэгцээт түвшинд бүрэн нийцсэн төгсөгчдийг бэлтгэн гаргадаг”, “Би төгсөхдөө нягтлан бодогч ажлын байранд шууд ажиллахуйц чадварыг эзэмшсэн байсан”, мөн “Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн мэдлэгийг хангалттай түвшинд эзэмшсэн” гэсэн асуултуудад төгсөгчдийн 56-60 хувь нь дундаас доогуур үнэлгээ өгсөн байв. Энэ бол багш нарын өөрийн үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ төгсөгчдийнхтэй эрс зөрүүтэй байгааг харуулж байна. Үүнээс гадна ажил олгогчид шинээр төгссөн нягтлан бодогч мэргэжилтний мэдлэг ур чадвар, мөн ёс зүйн болон харилцааны ур чадварын дутагдлын талаар тааруу (50 хувиас доош) сэтгэгдэлтэй байв. Эндээс үзэхэд, манай нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиуд төгсөгчдийнхөө зах зээлийн шаардлагыг судлаагүй, тэдэнд ямар чадвар шаардлагатай талаар мэдээлэлгүй, таамгаар сургалтын ажилд ханддагийг харуулж байна. Сургуулиуд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарын талаар хариуцлага хүлээдэггүй, борлуулалтын дараах үйлчилгээ, баталгаат хугацаа гэж байдаггүй, энэ талаар хянаж шалгадаг байгууллага байхгүй, үүнээс болоод нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэх нь ашиг олох хэрэгсэл гэж үзэх хандлага газар аваад байна.

Ийм чанаргүй мэргэжилтэн бэлтгэж байгаа учраас бидний судалгаагаар 12 сарын хугацаанд улсын хэмжээнд 324 нягтлан бодогч ажил олгогчийн санаачлагчаар (ажилдаа тэнцээгүй гэх мэт шалтгаанаар) халагдсан нь дээд боловсрол шаардах ажил мэргэжлийн дотроос хамгийн өндөр нь байв. Энэ бол тухайн жилд энэ мэргэжлээр нийт сургууль төгссөн мэргэжилтний 20 орчим хувийг эзэлж байгаа ажээ. Өөр нэг баримт бол хамгийн эрэлттэй, хомсдолтой ажил мэргэжлийн тоонд ерөнхий нягтлан бодогч ажлын байр 1 дүгээр байрыг эзэлж байхад улсын хэмжээнд нэг жилийн нийт төгсөгчдөөс илүү хэмжээний нягтлан бодогч мэргэжилтэн ажилгүй буюу ажил хайж байна.

3. Нягтлан бодогчдын олон улсын холбоо (НБОУХ)-ноос 2007 онд анх гаргасан бөгөөд 2014, 2015 оноос одоогийн хэлбэр, агуулгаар шинэчлэн батласан Нягтлан бодогч мэргэжилтний Боловсролын олон улсын стандарт (БОУС)-ыг нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг манай их, дээд сургуулиуд сургалтын хөтөлбөртөө тусгаагүй явж иржээ. Энэ бол манай нягтлан бодогч мэргэжилтний ур чадвар дэлхийн түвшинд хойгуур жагсаж байгаагийн нэг шалтгаан болж байна.
4. Сургуулиуд зах зээлийн буюу нийгмийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн оронд өөрийн сургуулийн чадвар бололцоонд тулгуурлан өөрөөр хэлбэл, багш нарын хүрэлцээ, тэднийхээ мэргэшил, чадварт таарсан мэргэжилтэн бэлтгэж байгааг зөвтгөх аргагүй. Зарим сургууль мэргэжлийн заавал судлах хичээлийн бүрэлдэхүүнд хамааралгүй

хичээлийг олон цагаар оруулж оюутныг хохироож байна. Сүүлийн арав гаруй жилд дээд боловсролыг оюутан төвтэй сургалтад шилжүүлэх асуудал ярианаас хэтрээгүй гэхэд хилсдэхээргүй байна. Энд нөлөөлж байгаа шалтгаан нь багшийн хүрэлцээ, багш нарын чадвар, бэлтгэл, заах арга зүйн дутагдал юм. Багш нараас авсан судалгаагаар тэдний 86 хувь нь багш нарын чадавхийг дээшлүүлэх, 75 хувь нь сургалтын арга зүйг сайжруулах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрсөн байна. Бидний судалгаагаар багш нар оюутан төвтэй сургалтын талаар мэдээлэлтэй боловч түүнийг хэрэгжүүлдэггүй, хэрэгжүүлэхийг шаарддаггүй, удирдлагын зүгээс зохион байгуулдаггүй, арга зүйгээр хангадаггүй байдал ажиглагдав.

Манай улсын инженер, техникийн мэргэжлийн зарим сургуульд гадаадын байгууллагуудын тусламжтайгаар оюутан төвтэй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлээд эхэлсэн туршлага байгаа ч түүнийг бусад сургуулиуд авч ашиглах, нутагшуулах ажиллагаа хангалтгүй байна. Ялангуяа, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх оюутан төвтэй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургууль байхгүй байна. Манай сургуулиуд хуучнаараа оюутан нь багшийг сонсох, ажиглах, дагах байдлаар сургалтад оролцдог, тэр нь оюутанд уйтгартай идэвхгүй байдлыг бий болгодог байдал үргэлжилсээр байна. Оюутан төвтэй сургалтаар бол сургалтын бүх үйл явцад оюутан идэвхтэй оролцох бололцоог хангадаг буюу мэргэжлийн хичээл нь дадлагад суурилсан

байдгаараа онцлогтой ажээ. Бүх мэргэжлийн сургуулиуд энэ чиглэлээр өөрчлөн байгуулагдах шаардлагатай болж байна.

5. Бидний судалгаанд оролцсон багш нарын 89 хувь нь “Оюутны мэдлэг чадварыг үнэлэх аргыг шинэчлэх” шаардлагатай гэсэн бол төгсөгчдийн 73 хувь нь “Оюутан суралцагчийн мэдлэгийн түвшнийг үнэн зөв үнэлэх хөндлөнгийн үнэлгээний шинэ систем хэрэгтэй” гэж үзсэн байв. Багш өөрийн уншсан лекцийн агуулгаар оюутнаас шалгалт аваад дүн гаргадаг байдлыг өөрчлөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл төгсөгчдийн чанарыг сайжруулахын тулд суралцагчдын ур чадварыг үнэлэх аргыг шинэчлэх шаардлагатай.

Тэгвэл хэрхэн шинэчилж өөрчлөх вэ?

Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах нь олон асуудлыг багтаасан цогц арга хэмжээ шаардлагатай болох нь ойлгомжтой. Эндээс хамгийн чухалд тооцож болох мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн асуудлыг хөндөж байгаа билээ.

БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д хөтөлбөрийн бүтцийг тодорхойлсон байдаг. Бакалаврын сургалтын хөтөлбөрийн батлагдсан бүтцийг олон улсын тэргүүлэх их, дээд сургуулиудын хөтөлбөртэй харьцуулахад ойролцоо байв. Иймээс энэ бүтцийг цаашид баримтлах боломжтой юм. Харин сургалтын хөтөлбөрийн бүрдэл хэсэг тус бүрээр нь дотоодын 10 их сургуулийн хөтөлбөрийг гадаадын тэргүүлэх 10 их сургуулийн хөтөлбөртэй зэрэгцүүлж үзэхэд ялгаа нэлээд ажиглагдсан. Түүнийг “Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийн чадавхийг

бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөмж, судалгааны тайлан"-д дурдсан (Сангийн Яам, 2021).

Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг цаашид боловсронгуй болгох нэг чиглэл нь Нягтлан бодогч мэргэжилтний боловсролын олон улсын стандартыг хөтөлбөртөө оруулах явдал юм. Учир нь манай улс нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартыг мөрддөг тул мэргэжилтний мэдлэг, ур чадвар түүнд тохирсон байх ёстой юм.

Боловсролын олон улсын стандарт НБОУХ-ны Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандартын зөвлөл (НБББОУСЗ)-өөс дараах 8 стандартыг баталж гаргаад байна (Сангийн Яам, 2021).

Дээрх стандартуудаас БОУС 2, 3, 4 дүгээр стандарт нь нягтлан бодогч мэргэжилтний мэдлэг чадвар, ёс зүй, хандлагад тавигдах шаардлагуудыг илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл нягтлан бодогч мэргэжилтэн дээрх 3 стандартад заасан мэдлэг, ур чадвар, ёс зүй, хандлагыг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай. Мөн дээрх стандартын шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэх 3 арга зам байгааг дээрх стандартаар тодорхойлжээ. Түүнд: академик сургалт буюу их, дээд сургуулиар мэргэжил эзэмших, мөн БОУС-5-ын дагуу практикт ажиллаж мэргэжил эзэмших, бас БОУС 6-ын дагуу эрх бүхий байгууллагад шалгалт өгөх замаар мэргэжил эзэмшиж болдог байна. Манай нөхцөлд эхний арга зам нь нээлттэй харин сүүлийн хоёр арга нь одоогоор хаалттай байгаа юм. Хэрэв БШУ-ны яам Үндэсний мэргэшлийн хүрээг баталж түүнд академик болон академик бус сургалтын мэргэшлийн түвшний

дүйцлийг тодорхойлж өгвөл дээр дурдсан БОУС бүрэн утгаараа хэрэгжих боломжтой болох юм.

БОУС-д нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтний мэргэшлийн суурь буюу анхан шат, дунд, ахисан буюу эксперт гэсэн 3 түвшнийг тогтоосон бөгөөд ахисан буюу эксперт түвшин нь нэг талаас академик боловсролын магистрын зэргийн боловсролын түвшинтэй, нөгөө талаас мэргэжлийн байгууллагын олгодог зэрэг буюу мэргэшсэн нягтлан бодогчийн ур чадвартай дүйцүүлдэг байна. Харин суурь нь дипломын, мөн дунд түвшин нь бакалаврын зэргийн боловсролын түвшинтэй дүйцдэг байна. Үүнийг дээр өгүүлсэн Үндэсний мэргэшлийн хүрээгээр шийдвэрлэдэг ажээ. Их Британийн жишээгээр бол АССА-гийн анхан шатны шалгалт өгч тэнцсэн хүнийг нягтлан бодох бүртгэлийн суурь мэдлэг эзэмшсэн бөгөөд данс хөтлөгч, эсвэл нягтлан бодох бүртгэлийн туслах ажлыг хийх чадвартай гэж үздэг, үүнийг их сургуулийн дипломын боловсролын түвшинтэй дүйцүүлдэг байна. Харин АССА-гийн хоёр дахь шатны бүлэг шалгалтыг өгч тэнцсэн хүнийг нягтлан бодогч мэргэжлийг эзэмшсэн бөгөөд байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалд ажиллах ур чадвартай гэж үздэг. Үүнийг их сургуулийн бакалаврын зэрэгтэй дүйцүүлдэг. Мөн АССА-гийн шалгалтыг бүрэн дүүргэсэн бол ахисан буюу эксперт түвшний боловсролтой, мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэг авах болзол хангасан гэж үздэг, үүнийг их сургуулийн магистрын түвшинтэй дүйцүүлдэг ажээ. Дээд боловсролын шинэчлэлийн явцад энэ асуудлыг хамтад нь шийдэх ёстой учраас дээр цухас өгүүлэв. Харин одоо БОУС-ыг сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгах асуудалд эргэж

оръё.

Мэргэжлийн нягтлан бодогч гэж мэргэжлийн чадамжийг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшсэн хувь хүнийг хэлнэ гэж БОУС-д тодорхойлжээ.

Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол нь ерөнхий боловсрол дээр суурилсан (а) техник чадамж, (б) мэргэжлийн ур чадвар болон (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг эзэмшүүлэх сургалт юм.

Нягтлан бодогч мэргэжилтний
техник чадамж

Мэргэжлийн техник чадамж гэдэг нь дараах 11 чадамжийг суралцагчдад эзэмшүүлэх явдал юм.

1. Санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал
2. Удирдлагын нягтлан бодох бүртгэл
3. Санхүү, санхүүгийн удирдлага
4. Татвар
5. Аудит ба баталгаажуулалт
6. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт
7. Бизнесийн эрхзүй
8. Мэдээллийн технологи
9. Байгууллагын хүрээлэн буй орчин болон бизнесийн орчин
10. Эдийн засаг
11. Бизнесийн стратеги болон удирдлага.

БОУС 2-т дээр дурдсан мэргэжлийн чадамжийн хүрээ тус бүрд суралцахуйн үр дүнг тодорхойлсон байдаг. Чадамжийн хүрээ тус бүрийг тодорхой хичээлүүдэд задалж өөрөөр хэлбэл тухайн чадамжийг ямар хичээлээр олгох хичээлүүд нь хоорондоо хэрхэн интегралчлагдах байдлыг олон улсын тэргүүлэх их сургуулийн туршлагаас харж болно (Сангийн Яам, 2021).

Нягтлан бодогч мэргэжилтний
мэргэжлийн ур чадвар

БОУС 3 стандарт нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, мэргэжлийн ажлын чанарыг сайжруулах, НББ-ийн мэргэжлийн итгэл үнэмшлийг бий болгох зорилгоор нягтлан бодогч болохоор эрмэлзэж буй мэргэжилтнүүдэд заавал эзэмшсэн байвал зохих ур чадваруудыг тодорхойлдог. Үүнд:

- **Оюуны ур чадвар (intellectual):** мэргэжлийн нягтлан бодогч асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгөх чадварууд хамаардаг.
- **Олон талт харилцааны ур чадвар (interpersonal and communication):** мэргэжлийн нягтлан бодогчийн бусадтай үр нөлөөтэй харилцан ажиллах чадварыг хамааруулна.
- **Хувь хүний ур чадвар (personal):** мэргэжлийн нягтлан бодогчийн зан төлөв болон хувь хүний хандлагуудыг хамааруулна.
- **Зохион байгуулалтын ур чадвар (organizational):** мэргэжлийн нягтлан бодогч нь байгууллагадаа үр өгөөжтэй ажиллахын тулд ажилчид болон боломжит нөөцүүдээс оновчтой үр дүнг олж авах чадварыг хамааруулна.

Мөн мэргэжлийн нягтлан бодогч нь техникийн чадамж, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй болон хандлагуудыг нэгтгэсэн мэргэжлийн чадамжуудаар дээрх мэргэжлийн ур чадварыг харуулах ёстой гэж зааварчилсан байдаг.

Мэргэжлийн нягтлан бодогчийн суралцахуйн үр дүнд заавал эзэмшсэн байх ёстой ур чадварууд нь ирээдүйд НББ-ийн янз бүрийн мэргэшлээр мэргэшиж өөрийгөө хөгжүүлэх боломжийг бий болгоход суурь болж өгдөг байна.

Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлага БОУС 4 нь нягтлан бодогч мэргэжилтний мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг тодорхойлсон байна. Энэ стандартын зорилго нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид ирээдүйд мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргээ биелүүлэхийн тулд мэргэжлийг эзэмших явцад эзэмшсэн байвал зохих мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг тодорхойлсонд оршино.

Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогчдыг мэргэжлийн эзэн болгож буй мэргэжлийн зан төлөв болон шинж чанарыг хэлнэ. Үүнд, мэргэжлийн зан төлвийн ялгаатай шинж чанарыг тодорхойлоход чухалд тооцогдох, ерөнхий холбогдолтой ёс зүйн зарчмууд багтана. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагад дараах чанарууд багтана:

1. Мэргэжлийн үл итгэх байр суурь ба мэргэжлийн үнэлэлт - үл итгэх байр сууринаас буюу шүүмжит сэтгэлгээгээр асуудалд хандах, нэг талыг барьсан шийдвэр гаргахаас зайлсхийх чадвартай байх,
2. Ёс зүйн зарчим - шударга байдал, бодитой хандлага, мэргэжлийн ур чадвар, хянамгай байдал, нууцыг хадгалах, мэргэжлийн зан төлөв (Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, 2013),
3. Нийтийн ашиг сонирхлын төлөөх үүрэг (бизнес, сайн засаглал, хууль, дүрэм, журам гэх мэт бүхий л зүйлд нийгмийн, байгууллагын, мэргэжлийн, хувь хүний ёс зүйг анхааран үздэг байх).

Хандлагын хувьд:

1. Мэргэжлийн эерэг хандлага - хянамгай байх, цаг хугацааг баримтлах, эелдэг найрсаг, хүндэтгэлтэй, хариуцлагатай,

найдвартай байх,

2. Илүү шилдэг болоход тэмүүлэх - тасралтгүй хөгжиж, насан туршдаа суралцахад бэлэн байх,
3. Нийгмийн хариуцлага - улсын, орон нутгийн, байгууллагын олон нийтийн ашиг сонирхлыг ойлгож, анхаарч, дэмжлэг үзүүлдэг байх.

Манай их сургуулиуд БОУС 2, 3, 4-т заасан ур чадвар бүхий нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэх нь Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн хариуцлага болоод байгаа юм.

Сургалтын хөтөлбөрийн талаарх судалгааны дүгнэлт, санал

Бид нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн судалгааны явцад сургуулиуд болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд нэлээд асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байгааг анзаарсан юм. Тухайлбал:

1. Олон улсын дээд боловсролын шинэчлэлийн агуулга нь хуучин масс үйлдвэрлэлийн системээс оюутан бүрийн сонирхолд тулгуурласан олон сонголтой хичээл бүхий либерал арт загварт, багш төвтэй сургалтаас оюутан өөрөө өөрийнхөө сургалтыг удирддаг оюутан төвтэй сургалтад, орцыг бус гарцыг буюу суралцагчийн чадамжаар үнэлдэг системд шилжиж байна. Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг Монгол Улсын их, дээд сургуулиудын дүр төрх ийм байх ёстой.
2. Манай улсын сонгогдсон их сургуулиудын НББ-ийн сургалтын хөтөлбөрийн зорилгод шинжилгээ хийхэд хэт ерөнхийлсөн, ялангуяа “Мэргэжлийн нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлан

- бэлтгэх чадвартай байна” гэсэн НББ-ийн тухай хуулийн санааг заримд нь тусаагүй байна. Хөтөлбөрийн зорилго, агуулгад бэлтгэх мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүй, хандлагын хувьд БОУС-д заасан шаардлагыг хангах асуудлыг тусгах нь зүйтэй.
3. Судалгаанд хамрагдсан гадаадын тэргүүлэх их сургуулиудад бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь өргөн цар хүрээний мэдлэг, чадвар (чадамж) эзэмшүүлэхээс гадна уян хатан, интегралчилсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилго тавьж байна. Нягтлан бодогч мэргэжлийн ажлын байранд нэн тэргүүнд тулгарах ERP систем нэвтрүүлэлт болон хиймэл оюун ухааны хэрэглээний нөлөөнөөс үүсэх ажил үүргийн хуваарийн өөрчлөлт, ажлын байрны шилжилт, өөрчлөлт зэрэгт тохирсон уян хатан бөгөөд интегралчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах хэрэгцээ мөн адил дотоодын их, дээд сургуулиудад тулгарч байна.
 4. Гадаадын тэргүүлэх их сургуулиудад хөтөлбөрийн зорилгоос хамааран бакалаврын хөтөлбөрөөр дараах зэрэг олгож байна. Үүнд: BBA-Bachelor of Business Administration in Accounting зэрэг нь бизнесийн өргөн хүрээний мэдлэг олгох зорилготой ерөнхий эрдмийн болон бизнесийн шинжилгээний хичээлүүд сургалтын төлөвлөгөөнд эзлэх хувь нь өндөр, харин BSc-Bachelor of Science (Hons) in Accounting зэрэг нь математик загварчлал болон статистикийн аргыг нягтлан бодох бүртгэл дэх хэрэглээг дэмжсэн, шинжлэх ухааны хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд тусгасан буюу илүү мэргэжлийн чиглэлд мэргэшүүлэх байдлаар сургалтын онцлог харагдаж байна. Мөн BA-Bachelor of Accounting зэрэг нь мэргэшүүлэх байгууллагын зэрэг дэвийг хүртэхэд дэмжлэг болох хөтөлбөрийг санал болгож байна. Энэ туршлагыг харгалзан манай их, дээд сургуулиуд НББ-ийн хөтөлбөрөөр ямар зэрэг дэвийг олгохоо тодорхойлж, түүнд тохирсон ялгаатай хөтөлбөрийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, элсэгч, суралцагч нь өөрийн карьер өсөлт, ажиллахаар төлөвлөж буй байгууллагад тохирсон хөтөлбөрийг сонгох нь төгсөгчдийн ажил эрхлэлт нэмэгдүүлэх, мэргэжилдээ дурлах, тогтвортой ажиллах, цаашдын карьер өсөлтийг тодорхойлоход дэмжлэг болох юм.
 5. Гадаадын тэргүүлэх их сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн агуулгыг нэгтгэн үзэхэд 50% нь ерөнхий стандарт болгож болохоор давхцал харагдаж байв. Тиймээс манай их, дээд сургуулиуд НББ-ийн мэргэжлийн сургалтын агуулгыг тодорхойлохдоо үүнийг анхаарч сургалтын төлөвлөгөөнд тусгавал олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэх зорилтыг хангах, төгсөгчдийн чанарыг дээшлүүлэх ач холбогдолтой байж болох юм.
 6. Гадаадын тэргүүлэх сургуулийн хөтөлбөрт мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхээс гадна оюутанд харилцааны ур чадвар, шүүмжит сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх болон өөрийн үнэт

- зүйлийг тодорхойлох чадвар бүхий нийгмийн иргэн байх чадвар олгоход анхаарал хандуулж байна. Мөн эдгээр тэргүүлэх их сургуулиудын хувьд сонгон судлах хичээлийн багцуудад анхаарал татахуйц онцлог дараах агуулга бүхий хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд тусгасан байна (Сангийн Яам, 2021, 153-216 дах тал). Үүнд:
- Энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийн үнэ цэнийг бий болгоход шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгох,
 - Бизнесийн процессыг танин мэдэх, уялдаа холбоог ойлгох, процессыг сайжруулах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл технологийг ашиглах чадвар олгох,
 - Орчин үеийн ажлын байрны сэтгэл судлал, карьер өсөлтийн төлөвлөгөө,
 - Хиймэл оюун ухаан ба бизнесийн инноваци зэрэг болно.
7. Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн агуулга нь БШУЯ-наас тавьж байгаа шаардлагыг ихэнх сургууль хангаж байгаа боловч ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийн харьцааг механикаар тохируулсан, ямар түвшний мэдлэг, чадвар олговол зохистой болохыг анхаараагүй байна.
8. Цөөн тооны оюутан, багштай сургуулиуд багшийн нөөц, мэргэшил чадамжид нь тохирсон хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд түлхүү оруулах байдал түгээмэл ажиглагддаг. Тэр ч байтугай ерөнхий эрдмийн хичээл ордог багшид олон оюутан ногдож байвал эдийн засгийн хувьд ашигтай байдаг гэсэн хандлага нь мэргэжлийн хичээлийг цөөрүүлэх, багшийн нөөцийг багасгахад нөлөөлдөг байна.
9. Багш нар хичээлийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалыг шингээж оюутан төвтэй, идэвхтэй суралцахуйг дэмжсэн сургалт, үнэлгээний арга зүйг тусгадаг болсон сайн жишиг байна. Судалж буй сэдэв бүр хичээлийн зорилтот үр дүнд хувь нэмэр оруулах, хичээл бүр хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнд хувь нэмэр оруулах уялдааг харуулах хичээлийн болон хөтөлбөрийн матрицын загварыг хөтөлбөрийн боловсруулалтад ашигладаг байх шаардлагатай.
10. Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалыг нэвтрүүлэхийн тулд оюутан төвтэй сургалт буюу идэвхтэй сургалтын арга зүйд тохирсон анги танхим, номын сан, лаборатори, төвүүд ямар байх, сургалтын хэрэглэгдэхүүн, мэдээллийн технологи, программ хангамж юу байх, ямар шаардлагыг хангасан байх, хэн хариуцаж, оюутан хэрхэн ашиглах талаар хөтөлбөрийн бусад хэсэгтэй уялдаа хангалтгүй байна. Мөн ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл, сургалтын хэрэглэгдэхүүн, нээлттэй эх сурвалжийн талаар хөтөлбөрт тусгаагүй зэрэг анхаарах асуудлууд байна. Оюутан төвтэй сургалтад тохируулан сургалтын орчин, нөхцлийг өөрчлөн байгуулах шаардлага тулгарч байгааг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх шаардлагатай.
11. Суралцагчийн мэдлэгийн байдлыг үнэлэх хандлага түгээмэл байгаа бөгөөд харин суралцагчийн чадамж буюу сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээ хангалтгүй байна. Суралцагчийн тухайн хөтөлбөрөөр суралцах нийт хугацаанд суралцахуйн үр дүнг

- үнэлэхэд олон улсын туршлагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг болох нь зүйтэй.
12. Сургалтын хөтөлбөрт жил бүр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, ажил олгогчдын шинэ хэрэгцээ шаардлагыг судалгаанд тулгуурлан тодорхойлж, үр дүнг хөтөлбөртөө тусгадаг байвал зохино. Дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ)-ууд чанарын дотоод баталгаажуулалтын алба байгуулж хөтөлбөр бүрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийлгэдэг болох, дэргэдээ олон талын оролцоотой мэргэжлийн зөвлөл байгуулж, санал зөвлөмжийг авч байх, ММНБИ, МНББХ, ТИНЗ, МҮН зэрэг мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, зөвлөмж зөвлөгөөг нь хэрэгжүүлдэг байх шаардлагатай.
 13. Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиуд хамтран “Нягтлан бодох бүртгэлийн багшийн хөгжлийн төв”-ийг байгуулж, профессор багш нарыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхийн зэрэгцээ сургуулиудын хамтарсан сурах бичиг зохиох боломжийг бүрдүүлэх.
 14. Их сургууль бүр олон тооны томоохон ажил олгогчтой хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, суралцагчдыг дадлагажуулах, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, хөтөлбөрийн үр дүнд сэтгэл ханамжийн судалгаа авах, байгууллагын үйл ажиллагааг харилцагч байгууллагуудтай уялдуулах зэргээр хамтын ажиллагааны хэлбэрийг хөтөлбөрт тусгах явдал дутагдалтай байна.
 15. Дэлхийн тэргүүлэх их сургуулиудын туршлагаас үзэхэд сургуулиуд сургалтын хөтөлбөрийг аль болох нээлттэй олон нийтэд танилцуулж хөтөлбөрөөр өрсөлдөж байна. Элсэгчид сургуулиудын хөтөлбөрийг харж байж мэргэжлийн сонголт хийдэг, ажил олгогчид сургуулиудын хөтөлбөрийг судлаад тухайн ажлын байранд тохирох мэргэжилтнээ сонгодог учиртай. Гэтэл дээрх сургуулиудаас дөнгөж 4 сургууль вэб сайтдаа хөтөлбөрөө тавьсан байв. Цаашид сургуулиуд хөтөлбөрөө байнга шинэчилж сайжруулдаг, нээлттэй танилцуулдаг байх нь зүйтэй.
- Манай судалгааны явцад БШУЯ-ны анхаарвал зохих зарим асуудал байв. Үүнд:
- 1) Дээд боловсролын талаар баримтлах бодлого, шийдвэр, эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх шалгуур, стандарт, аргачлалыг гүйцээн боловсруулж их сургуулиудыг иж бүрэн арга зүйгээр хангаж ажиллах.
 - 2) ДБСБ-ын бүх шатны сургалтын хөтөлбөрт стандарт, шалгуур, шаардлагын дагуу үнэлгээ хийж боловсруулалтын түвшнийг тогтоох ажлыг үр дүнтэй хэлбэрээр, тогтмол зохион байгуулж байх, мөн НББ-ийн хөтөлбөрөөр төгсөн гарах мэргэжилтний мэдлэг, ёс зүй, ур чадварын шаардлага, стандартыг БОУС-ын дагуу боловсруулахад Сангийн Яам, мэргэжлийн бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах, батлагдсан шаардлага, стандартыг хэрэгжүүлж ажиллахыг ДБСБ-аас шаардах.
 - 3) Их, дээд сургуулиуд кредитийг харилцан хүлээн зөвшөөрөх нэгдсэн тогтолцооны хүрээнд оюутны мэдлэг чадварыг бодитой үнэлэх, түүний биелүүлсэн кредитийн хөрвөх

- нөхцлийг хангахад чиглэх ёстой боловч суралцагчийн үнэлгээний лавлах хүснэгтээс харахад үнэлгээний янз бүрийн систем үйлчилж байна. Тухайлбал, ХААИС, МИС, СЭЗИС, ХУИС, ИЗОУИС 12 рейтингээр, МУИС, ХҮИС, ОТИС 9 рейтингээр, МҮИС 5 рейтингээр үнэлж байна. Тиймээс үнэлгээний системийг Монгол Улсын хэмжээнд ижилсүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх.
- 4) Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг их сургуульд суралцагч, төгсөгчдийн мэргэжлийн техник чадамж, ёс зүй, хандлагад тавих шаардлагын байдлыг үнэлэх, сургуулиудын чансааг тогтоох ажлыг жил бүр Сангийн Яамны оролцоотой хамтарсан мэргэжлийн байгууллагууд оролцсон ажлын хэсэг томилон зохион байгуулж хэвших.
 - 5) Нягтлан бодогч мэргэжлээр суралцагч оюутны мэдлэгийн түвшнийг жил бүр тогтоох болон төгсөгчдийн мэргэжлийн шалгалтыг нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагын оролцоотой хөндлөнгийн шалгалтын комиссоор авахуулдаг болох.
 - 6) БШУЯ-наас 2020 онд “ДБСБ-ын багшид тавих нийтлэг шаардлага”-ыг боловсруулж баталсан. Үүнийг үндэслэн НББ-ийн мэргэжлийн багшид тавих тусгай шаардлагыг боловсруулж батлуулах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ багшийн хөгжлийг дэмжих, сайжруулах нөхцлийг бий болгох нь зүйтэй байгаа юм.
 - 7) Их сургуулиудад чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан нэгж байгуулахад дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчныг бий болгох.
 - 8) Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг 41 их, дээд сургууль байгаагаас 4 сургууль хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсон байна. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд ороогүй чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг зогсоож, цаашид сургуулиуд 3 жил тутамд сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлдэг болох, энэ ажилд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг давуу эрхтэй оролцуулдаг болох нь зүйтэй.
 - 9) Нийт 41 сургууль НББ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 200-аас дээш суралцагчтай 10 сургууль, 40-өөс дээш суралцагчтай нийт 20 сургууль байна. Бусад нь маш цөөн суралцагчидтай. Хэт цөөн суралцагчтай хөтөлбөрүүдэд багшийн хүрэлцээ хүндрэлтэй, цаашлаад сургалтын чанартай шууд холбогдох тул тухайн хөтөлбөрөөр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудалд суралцагчийн тоо, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг анхаарч үзэх шаардлагатай байна.
 - 10) Нягтлан бодогч бэлтгэн гаргадаг Мэргэжлийн байгууллага; Их, дээд сургуулиуд сургалтын хөтөлбөрөө БОУС болон мэргэжлийн үндэсний чадамжийн хүрээнд нийцүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Мэргэжлийн нягтлан бодогчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, ёс зүйн хандлага болон сургалтын хөтөлбөрүүдийг сайжруулах, чанарын баталгаажуулалт хийхийн тулд СЯ, БШУЯ болон ММНБИ-ийн оролцоотойгоор БОУС-н минимум шаардлагад нийцсэн “Мэргэжлийн нягтлан бодогчийн чадамжийн хүрээ”-г нь боловсруулах нь зүйтэй.

Ашигласан материал

Сангийн Яам (2021). Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөмж, судалгааны тайлан - www.mof.gov.mn.

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн (2013). Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм - www.mains.mn.